



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬАА

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө 10, Багшийн хөгжлийн ордон,
Утас, факс: (976) 7014 0069, <http://www.itpd.mn>

2018.05.25. № 1/165.

танай _____-ны № _____-г

Төрийн албан хаагчийн тэтгэлэгт
хөтөлбөрт хамруулах тухай

Япон улсын Нагояа их сургуулиас төрийн албан хаагчдад зориулсан докторын тэтгэлэгт хөтөлбөр зарлаж, шаардлага хангасан боловсролын салбарын төрийн албан хаагч, багш судлаачдыг чадваржуулан сургахыг хүсэж буй тухайгаа манай байгууллагад албан ёсоор хандлаа. Иймд та бүхэн өөрийн байгууллагын хүний нөөцөө чадваржуулах, багшийн хөгжлийг дэмжих, боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийх энэхүү боломжийг үр дүнтэй ашиглахыг хүсье. Хөтөлбөрт хамрагдах иргэн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Англи хэлээр магистрын дипломын ажил бичиж хамгаалсан
- Хэрвээ магистрынхаа дипломын ажлыг англи хэлээр бичээгүй бол бичих чадвартайгаа батлахуйц өгүүлэл нийтлэлийг англи хэлээр бичиж нийтлүүлсэн
- Төрийн албанд тогтвор сууршилтай ажилласан байх.

Дээрх шаардлагыг хангасан боловсролын салбарын ажилтныг Япон улсын Нагояа их сургуулийн Монгол дахь төлөөлөгчийн газарт хандаж материал бүрдүүлэн өгөхийг зөвлөнө үү. Бусад дэлгэрэнгүй мэдээллийг 76115758 утсаар болон Улаанбаатар хот, Туушин тауэрийн 3-309 тоотод байрлах тус төлөөлөгчийн газар биеэр уулзаж авна. Энэ хөтөлбөр нь зайны сургалтыг уламжлалт сургалтын хэлбэртэй хослуулан хэрэглэж, төрийн албанд ажил үүргээ гүйцэтгэхийн хажуугаар Нагояагийн их сургуульд суралцаж, докторын зэрэг хамгаалах боломжийг Монгол Улсын иргэнд олгож буйгаараа онцлог юм. Эзэн хааны нэрэмжит энэхүү тэтгэлэгт хөтөлбөрт жилд нэг удаа Нагояагийн их сургуульд ирэх очих замын зардал, сургалтын төлбөр, байрны зардал багтаж байгаа болно. Тэтгэлэгтэйгээр мөн ажлаасаа хөндийрөлгүйгээр боловсролоо дээшлүүлэх энэхүү хөтөлбөрт мэргэжилтнүүдээ хамруулна уу.

Цаашид энэ хөтөлбөр үргэлжлэн хэрэгжих бөгөөд дараа дараагийн жилүүдэд шаардлага хангасан багш, боловсролын салбарын ажилтнуудаа чадваржуулан сурахад өөрийгөө бэлтгэх талаар мэдээллийг хүргэнэ үү.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮРЭНЧИМЭГ

2018 0341